

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2017 ОНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ

НЭГ. Зам, тээврийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар

Зам, тээврийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Түүнчлэн иргэний нисэх, төмөр замын тээвэр, автотээвэр, далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус боловсруулж байна.

НҮБ-ын “Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт ашиглаж болох тоног, төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай, эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт нэгдэн орох хуулийн төсөл, Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох хуулийн төсөл, авто зам болон автотээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинээр, төмөр замын тээвэр болон иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж байна.

ХОЁР. Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр

БНХАУ-ын Бээжин хотноо 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан “Транзит Монгол-2017” форумд Монголын талаас Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл, “Улаанбаатар төмөр зам”-ын дарга Д.Жигжиднямаа тэргүүтэй холбогдох албаны хүмүүс болон манай улсын тээвэр зуучлалын компаниудын төлөөллүүд, БНХАУ-ын талаас Хөгжил шинэтгэлийн хороо, Худалдааны яам, Улсын төмөр замын газар, Нүүрсний холбоо тэргүүтэй тээвэр зуучийн компаниуд, ОХУ-ын талаас Тээврийн яамны харьяа Холбооны төмөр замын агентлаг, “Оросын төмөр замууд” НХН, Буриад Улсын төлөөлөгчид тус тус оролцсон.

Тус форумгаар БНХАУ Монголын транзит урсгалыг нэмэгдүүлэхээ амлан Тяньжин-Эрээн чиглэлд ачаа хүлээн авах чадварыг сайжруулж, Монгол Улсын нутаг дэвсгэр чиглэсэн ачаа урсгалыг нэмэгдүүлэх, үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хэлэлцсэн байна. Мөн Тавантолгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт, Ханги-Мандал чиглэлийн төмөр замын талаар санал солилцсон.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр Хятад-Европын чиглэлд 2016 онд 167 ширхэг чингэлгийн галт тэрэг тээвэрлэсэн нь өмнөх оноос 2 дахин гаруй нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд цаашид дамжин өнгөрөх чингэлгийн галт тэрэгний тоог 1000 хүргэх боломжтой гэж төсөөлж байна. ЗТХЯ болон УБТЗ ХНН-ийн зүгээс Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажилласны үр дүнд дамжин өнгөрөх чингэлэг тээврийн шилжүүлэн ачилтын тарифыг 70 хувиар, тээврийн тарифыг 15 хувиар тус тус бууруулсан шийдвэр гарсан.

ОХУ-ын Москва хотноо 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдөр болсон “Монгол, Орос, Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гурван талын шинжээчдийн түвшний хоёрдугаар уулзалтад Монгол Улсын Гадаад харилцааны яам ахалсан Монголын талын бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны төлөөлөл оролцсон болно. Тус уулзалтаар 3 талын хүлээн зөвшөөрсөн нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад зам, тээврийн салбарын 2 төслийг тусгахаар болов. Үүнд:

1. Төмөр замын Төв коридор (Улаан-Үд-Наушки-Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд-Эрээн-Улаанцав-Жанчхүү-Бээжин-Тяньжин)-ыг шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах эдийн засгийн үндэслэлийг судлах;
2. Азийн авто замын сүлжээний АН-3 (Улаан-Үд-Хиагт/Алтанбулаг-Дархан-Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүд/Эрээн-Бээжингийн гаднах тойрог-Тяньжин) чиглэлийг дамжин

өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах, тус чиглэлд хурдны авто зам барих эдийн засгийн үндэслэлийг судлах;

Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн 13 дахь хуралдаан ОХУ-ын Москва хотноо 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 29-ний өдрийн хооронд болсон бөгөөд Монголын талыг ЗТХ Дэд сайд Б.Цогтгэрэл ахалж оролцон хуралдаанаар 12 асуудал хэлэлцэж протокол байгуулсан. Мөн үеэр Дэд сайд Б.Цогтгэрэл ОХУ тээврийн сайдын орлогч А.В. Лушниковтой хоёр талын уулзалт хийж тээврийн салбарын хамтын ажиллагааны асуудлаар ярилцсан. Үүний үр дүнд удаан жил яригдаж ирсэн төмөр замаар дамжуулан тээвэрлэх ачааны нөхцөлийн тухай хоёр улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг тохирсон болно.

ГУРАВ. Авто замын салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд авто замын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн авто замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд 2017 онд 21 чиглэлийн 1412.77 км хатуу хучилттай авто зам, 3 байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга болон их засварын ажлыг Улсын төсвийн 5.29 тэрбум төгрөг, Хөгжлийн банкны 23.84 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжийн 509.93 тэрбум төгрөг, нийт 539.06 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэнэ.

Үүнээс шинээр 7 чиглэлийн 506.5 км авто замын барилга болон их засварын ажлыг эхлүүлэхээр, он дамжин хийгдэж байгаа 14 чиглэлийн 973.26 км авто зам болон 3 байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Тухайлбал гадаадын зээл, тусламжаар Азийн авто замын сүлжээний АН4 чиглэл буюу Баруун босоо тэнхлэгийн Ховд-Баян-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил, Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам, Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.2 км хурдны авто замын барилгын ажил хийгдэж байна.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй 3 төсөлд хуваарилагдсан нийт хөрөнгөөс 24.98 сая ам.доллар хэмнэгдсэн. Энэ хөрөнгөөр Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын үлдэгдэл ажлыг санхүүжүүлэхээр БНХАУ-ын Эксим банктай тохиролцоод байна.

Мөн концессын тухай хуулийн дагуу “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км цементбетон хучилттай 1-р зэргийн 4 эгнээ бүхий авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км их даацын хатуу хучилттай авто зам, Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км их даацын хатуу хучилттай авто зам”-ын төслүүдийг Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 166 тоот тогтоолоор нэмэлтээр оруулахаар баталсан.

Авто замын салбарт он дамжин баригдаж буй авто зам, гүүрийг энэ онд дуусган ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилга угсралтын ажил 90%, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй авто замын барилга, гүүрийн их засварын ажил 75%, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар /Концессын гэрээгээр/ хэрэгжиж авто зам, хөвдөг гүүрийн барилгын ажил 90%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Авто замын салбарт 2017 онд дараах 7 чиглэлийн 506.7 км авто замын барилга, их засварын ажлыг шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд барилгын ажлын явц:

- Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг Концессын гэрээгээр,
- Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг Концессын гэрээгээр,
- Дашинчилин-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг Концессын гэрээгээр,
- Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 17 км замын их засварын ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр,
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.5 км /Баян-Өлгий, Өлгий сум/ ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр,
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт 4.3 км /Ховд, Жаргалант/ ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр,
- Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл барилгын ажлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хэмнэгдсэн хөрөнгийн эх үүсвэрээр тус тус эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зорилтын хүрээнд 2017 онд Дорнод аймаг, 2018-2020 онд Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбоно.

ДӨРӨВ. Төмөр замын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар:

Монгол Улсын Засгийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төмөр замын тээврийн салбарын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр 2017-2018 онд дараах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход чухал ач холбогдол бүхий Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц 51,8%-тай байна. Энэхүү төмөр замын барилгын ажлыг 2014 оны 11 сараас санхүүжилтгүйн улмаас зогссон байсныг Засгийн газрын 2017 оны 222 дугаар тогтоолоор тус төмөр замын төслийн барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас Монгол Улсын Засгийн газарт хөнгөлөлттэй зээлээр олгох 1 тэрбум ам.доллараас 400 сая долларыг олгохоор шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас тус 400 сая ам.долларын 5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 2018 оны Улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна.

Нарийнсухайтын сав газраас олборлож буй нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж баталлаа. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж дууссан бөгөөд төслийг 2017 онд багтаан эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

“Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгагдсан төмөр замын зүүн коридорыг байгуулах ажлын хүрээнд Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай хөрөнгийг гадаадын зээл тусламжаар шийдвэрлэж барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг боловсруулж дууссан бөгөөд төмөр замын чигийг баталсан болно. Барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэснээр тус төслийг эхлүүлэхэд бэлэн байна.

Энэхүү хөтөлбөрт тусгагдсан төмөр замын хойд коридорын Эрдэнэт-Овоот төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх концессын гэрээг 2015 онд байгуулсан. Концесс эзэмшигч төмөр замын ТЭЗҮ-ийг 2017 оны 06 дугаар сард боловсруулж дуусгах бөгөөд энэ онд багтаан барилгын санхүүжилтийг шийдвэрлэж барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төмөр зам баригдсанаар Монгол, Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн ачаа тээврийн хэмжээ үлэмж нэмэгдэх юм.

Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал, агаар орчны бохирдлыг бууруулахад чухал ач холбогдол бүхий “Богдхан” төмөр замын төслийг 2015 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулж түүний хүрээнд Техникийн туслалцаанд зориулж 1.5 сая ам.доллараас эхний ээлжид төмөр замын чигийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Тус судалгааны ажлын хүрээнд төмөр замын эхлэл, төгсгөлийн цэгийг тодорхойлох, чигийн оновчтой хувилбарыг сонгох ажлыг гүйцэтгэн 4 дүгээр улиралд бэлэн болгохоор ажиллаж байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын ачаа боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Замын-Үүд суманд холимог тээврийн логистикийн төвийн бүтээн байгуулалтыг 2016 онд эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл өнөөдрийн байдлаар 50 гаруй хувьтай байгаа бөгөөд 2018 онд бүрэн ашиглалтад оруулна. Энэхүү логистикийн төв нь жилдээ 5 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай байх юм.

ТАВ. Автотээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан “Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Архангай, Хэнтий аймгийн төвүүдэд зорчигч үйлчилгээний авто буудал барих зураг төслийг боловсруулан 2017 оны 05-р сард барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Орос, Монгол, Хятад гурван улсын “Эдийн засгийн коридор байгуулах” хөтөлбөрт тусгагдсан Азийн авто замын сүлжээгээр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 2016 оны 08 дугаар сард Тяньжин-Улаанбаатар-Улаан-Үд чиглэлийн гурван улсын туршилтын дамжин өнгөрөх тээврийг амжилттай зохион байгуулж, Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлээр дамжин өнгөрөх тээврийг 2018 оны 01-р сард эхлүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд 3 улсын тээврийн сайд нарын зөвлөлдөх уулзалт 2017 оны 08 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд ОХУ-ын Улаан-Үүд хотод зохион байгуулагдсан.
- Дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх зорилгоор Герман, Польш, Чех, Итали, Словак Улсуудтай автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах ажлыг эхлүүлсэн. БНЧех Улстай олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах тухай гэрээний төслийг харилцан солилцож судалж байна. 2017 оны 10 дугаар сард Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын ивээл дор зохион байгуулагдах “Хөгжлийн зам-тээвэр логистикийн хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурлын үеэр БНТурк Улс, ХБНГУ, БНЧехУлс, БНПольш Улсын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд Монгол Улсад тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх стратеги боловсруулах болон замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх төслүүдийг эхлүүлсэн бөгөөд эдгээр төслүүд нь нэг жилийн хугацаатай үргэлжилнэ.

- Эдийн засгийн хүндрэлтэй байгаа энэ цаг үед уул уурхайн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтийг хоногийн нэгдсэн графикаар зохион байгуулж байна. 2017 оны эхний 8 сарын байдлаар, автотээврээр 20,0 сая нүүрс тээвэрлэн БНХАУ-д экспортлоод байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Олон улсын болон улсын чанартай авто замын дагуу жолооч, зорчигчдод үйлчилгээ үзүүлэх, техникийн засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий цогцолборуудыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Орхон, Завхан аймгуудад барьж байгуулахаар зураг төсөл боловсруулж барилгын ажлуудыг эхлүүлэхэд бэлэн болгов.
- Зам, тээврийн ослоос учирч буй хохирлыг бууруулах зорилгоор олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, стандартад нийцүүлэн баруун талдаа жолооны хүрд бүхий тээврийн хэрэгслийн гэрлийн тусгалыг зүүн талдаа жолооны хүрд бүхий тээврийн хэрэгслийн гэрлийн тусгалтай нийцүүлэн өөрчлөх ажлыг эхлүүлээд байна.

ЗУРГАА. Агаарын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар:

Төв аймгийн Хөшигийн хөндийд Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Олон улсын нисэх онгоцны шинэ буудал баригдаж ашиглалтад орсноор Монгол Улсын агаарын тээврийн хөгжилд түлхэц өгч, улмаар дагуул хот, холимог тээврийн логистикийн төв байгуулагдан Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Говь-Алтай аймгийн Алтай хотын нисэх буудлыг шинэчлэн сайжруулах ажлыг 2016 оны 11 дүгээр сард дуусгаж, ашиглалтад хүлээн авсан.

Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Агаарын харилцааны тухай Монгол Улс, БНЧУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг, ХБНГУ-ын Лейпциг хотноо 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Агаарын харилцааны тухай Монгол Улс, Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тус байгуулав.

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын “Хоёр орны нутаг дэвсгэрт болон тэдгээрийн хилийн чанадад агаарын харилцаа тогтоох тухай” хэлэлцээрийн хүрээнд агаарын харилцааны асуудлаар БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамны төлөөлөгчидтэй Улаанбаатар хотноо 2017 оны 6 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд хэлэлцээ хийж, нислэгийн багтаамжийг суудлын тоогоор тохирох, аялалын дугаар хуваан ашиглах, агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх, ачаа тээврийн нислэгийн асуудлыг хэлэлцэж, эдгээр асуудлыг ирэх 10 дугаар сард өндөр хэмжээнд зохион байгуулах хоёр талын уулзалтаар хэлэлцэхээр тохирч, Уулзалтын тэмдэглэл хийсэн.

Агаарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар Тайландын Вант Улсын Тээврийн яамтай уулзалт, хэлэлцээ хийж, нислэгийн багтаамж, давтамж, аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт тохирч, 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Санамж бичиг байгуулсан;

Люксембургийн Их Вант Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Мальт Улс, Швейцарын Холбооны Улс, Тайландын Вант Улс, Камбожийн Вант Улсуудтай агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах ажил хийгдэж байна.

Энэ оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс Монгол Улсын агаарын зайн үзүүлэлтэд/ PBN/ тулгуурласан навигаци бүхий дамжин өнгөрөх нислэгийн 6 замыг агаарын хаалганаас хаалганд чиглэсэн чиг шулуун болгож, Улаанбаатар хотод хөөрөлт, буулт үйлдэх чиг шулуун агаарын зам тогтоон агаарын навигацийн үйлчилгээнд ашиглаж эхэлснээр БНХАУ болон Зүүн өмнөд Азийн

хотуудруу нислэг гүйцэтгэж буй дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэг төлөвлөлт хялбаршиж, нислэгийн зам богиносох давуу талыг бий болголоо.

Агаарын замуудыг ийнхүү шулуутгаснаар агаарын тээвэрлэгчид жилд 230 гаруй мянган км зам товчилж, дунджаар 1700 орчим тн түлш хэмнэж, нүүрсхүчлийн хийн ялгаралт 5220 тн-оор багасах тооцоо гарсан.

Энэ 2017 оны 5 дугаар сарын 31-ны байдлаар олон улсын өнгөрөлтийн 42287 нислэг, олон улсын хөөрөлт буултын 2498 нислэг, орон нутгийн хөөрөлт буултын 1850 нислэг гүйцэтгэгдсэн байна. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийнхтэй (37957) харьцуулахад 4330 нислэгээр буюу 11.4%-иар, олон улсын буулт хөөрөлтийн нислэгийг өмнөх оныхтой харьцуулбал 12.0 хувиар, орон нутгийн буулт хөөрөлтийн нислэгийг өмнөх оныхтой харьцуулбал 21.9 хувиар тус тус өссөн байна.

ДОЛОО. Далай, усан замын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар:

Сүүлийн жилүүдэд дотоод гадаадын аялагч амрагчдын тоо нэмэгдэж, гол нууруудад усан замын тээврийн хэрэгслээр аялж зугаалах иргэдийн тоо олширсонтой холбогдуулан дотоодын усан замын тээврийн салбарт зохион байгуулалттай, тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналт хариуцлагыг өндөржүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Монгол Улсын Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” үндэсний сургалт-семинарыг Далайн олон улсын байгууллага, Олон улсын эрэн хайх, авран хамгаалах холбоо, бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж 192 завь жолоодогчийг хамруулав.

Монгол Улс хөлөг онгоцны бүртгэлийг Сингапурын боомтод эрхэлж байгааг ойрын жилүүдэд Улаанбаатарт төвлөрүүлж бүртгэдэг болох, бүртгэгдсэн хөлөг онгоцны хяналтыг сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, бүртгэлийг чанаржуулах, улмаар агентын сүлжээг үүсгэх замаар бүртгэлийн ажлыг өргөжүүлэхээр ажиллаж байна.

Далайн боомт ашиглалтын хүрээнд БНХАУ, ОХУ, БНАСАУ, БНСУ, БНИУ-ын худалдааны далайн боомтуудыг Монгол Улсын гадаад худалдаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Тухайлбал энэ хүрээнд Бүгд Найрамдах Итали Улсын Генуя боомтыг таатай нөхцлөөр ашиглах талаар тохиролцож байна.

БНХАУ-ын Тяньжин дэх Дунзяны эдийн засгийн чөлөөт бүсийн 10 га газарт тээвэр, логистик, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор барьж ашиглах талаар Хятадын талтай тохиролцсон бөгөөд одоогоор төслийг “Монголын төмөр зам” ТӨХК 49%, Хятадын тал 51%-ийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

ЗАМ,ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ